



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

2025 оны 8 дугаар сар

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан Дорноговь аймгийн 31 байгууллагын нийт 594 эрх бүхий албан тушаалтнаас иргэн болон хуулийн этгээдэд ногдуулсан 2023, 2024 оны торгуулийн орлогын холбогдох баримт, мэдээллийг хамруулав.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчил шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор **ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ**-ийг 2017 онд баталсан.

АУДИТЫН ГОЛ ҮР ДҮН (НӨХЦӨЛ БАЙДАЛД СУУРИЛСАН ДҮГНЭЛТ):

ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУД ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨХӨД ХҮНДРЭЛТЭЙ БАЙНА.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүүгийн орлогыг 2023 онд 1,735.7 сая төгрөгөөр, 2024 онд 577.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь Азийн хөгжлийн банкнаас Чандмань-Илч ОНӨХХК-д шилжүүлэн авч өгсөн зээлийн гэрээ¹-ний дагуу төлөх хүүгийн төлбөр байна.

ТБОНӨХЭ-ийн хувьд, 2023 онд 5 байгууллага 97.7 сая төгрөгийн, 2024 онд 5 байгууллага 439.6 сая төгрөгийн хүүгийн орлого **төвлөрүүлсэн** байна. Эдгээрээс Нийгмийн даатгалын газар нь 2023, 2024 онуудад 130.9 сая төгрөгийн хүүгийн орлогыг төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл дунджаар 60.7 хувьтай байна. Мөн Дорноговь орон сууц ОНӨААТҮГ² нь түрээсийн орон сууцын зээлийн эргэн төлөлтийн мөнгөн дүн, хугацаа тодорхой учраас 362.1 сая төгрөгийн хүүгийн орлогыг төлөвлөж, 100.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь **төлөвлөлтийг тооцоо, судалгаатай** хийсэн байна.

Харин бусад байгууллагуудын хувьд тухайн өдөр болон сарын эцэс дэх харилцах дансны үлдэгдлийг **урьдчилан тооцоолох боломжгүй** тул төлөвлөхөд **хүндрэлтэй** байсаар байна.

Аймаг болон сумдын (Замын-Үүд сумаас бусад) торгуулийн орлогыг зөвхөн цагдаагийн торгуулийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. 2023-2024 оны торгуулийн орлогын гүйцэтгэлийг харахад дийлэнх тохиолдолд төлөвлөгөөнөөс

¹ Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны зээлийн төслийг хэрэгжүүлэх гэрээ

² Аймгийн хөгжлийн үндсэн чиглэлд тусгагдсан орон сууцжуулах бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгэж буй байгууллага

давсан бөгөөд Замын-Үүд суманд дунджаар 71.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гэнэтийн хүчин зүйлсээс шалтгаалсан байна.

Торгуулийн орлогыг хэт өндөр, **бодитой бус төлөвлөх** нь хууль сахиулагчдыг “орлого төвлөрүүлэгч” болгон хувиргаж, зөрчил бууруулах үндсэн зорилгыг алдагдуулах, иргэд болон бизнес эрхлэгчдийн төрд итгэх итгэл алдагдаж, торгуулийн дарамт мэдрүүлэх, ЭБАТ-уудад ашиг сонирхлын зөрчил үүсгэх зэрэг **олон сөрөг үр дагаврыг** бий болгох талтай ч нөгөө талаас торгууль нь хууль, журам сахиулах гол хөшүүрэг болсоор байна.

2. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХЭЭР ЗААСАН БОЛОВЧ УЛСЫН ТӨСӨВ БОЛОН БАЙГУУЛЛАГАД ТӨВЛӨРҮҮЛЖ БАЙНА.

Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хууль, эрх зүйн орчныг **хэрхэн бүрдүүлснийг схемчилбэл** дараах байдалтай байна.




Дээрх зураглалаас харахад торгох шийтгэлээр шийтгэгдсэн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй хэдий ч үүргийн хэрэгжилтийг хангахад **уян хатан нөхцөл** бий болгосон байна.

Шийтгэл оногдуулсан ЭБАТ нь шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хариуцахыг хуульд тодорхой зааснаас гадна хуулийн нэмэлт өөрчлөлтөөр торгуулийн орлогын бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлэх хэд хэдэн заалтыг нэмж баталсан байна. Жишээлбэл, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг **50 хувиар хөнгөрүүлэх** нь орлогын бүрдүүлэлт, бодит хэрэгцээ шаардлагад **эерэг нөлөөг** үзүүлж байна.

Дорноговь аймгийн хэмжээнд 2023-2024 онуудад нийт 26 байгууллагаас **8,159.4 сая** төгрөгийн торгуулийг ногдуулснаас **7,782.4 сая** төгрөгийг төвлөрүүлж, 377.0 сая төгрөгийн орлого дутуу байна. (**хөнгөлөлтөд хамрагдсан** торгуулийн дүн төвлөрүүлээгүй торгуулийн дүнд багтсан байх магадлалтай).

Барагдуулалт дутуу **377.0 сая төгрөгийн** торгуулийн 94 хувийг **цагдаагийн торгууль** эзэлж байгаа бөгөөд торгуулийн орлогыг **мөнгөн сууриар** бүртгэдэг бөгөөд дутуу төвлөрүүлсэн торгуулийн авлага санхүүгийн тайланд **тусгагддаггүй** байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “**аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого**”, 23.9.3-т “**сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: хууль тогтоомжийн дагуу сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт орох бусад орлого**” гэж заасан байна.



Нийт төвлөрсөн 7,782.4 сая төгрөгийн торгуулийн орлогын 39.1 хувь буюу 3,043.6 сая төгрөг нь **УЛСЫН ТӨСӨВТ**, 60.7 хувь буюу 4,728.0 сая төгрөг нь **орон нутгийн төсөвт**, 0.2 хувь буюу 10.8 сая төгрөг нь **БАЙГУУЛЛАГЫН ДАНСАНД** төвлөрсөн байна.

Хэрэв дээрх байгууллагуудын торгуулийн орлого Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрвөл татварын бус орлого жилд дунджаар **1,500.0 сая төгрөгөөр НЭМЭГДЭХ боломжтой** юм.

Аймгийн Прокурорын газраас 2023 онд 21,127, 2024 онд 21,293 зөрчлийн хэрэг бүртгэлтийг **хянасан** бөгөөд хууль, журамд заасан үндэслэлийг буруу хэрэглэсэн, нотлох баримт дутуу шалтгааны улмаас 2023 онд **143 зөрчил**, 2024 онд **622 зөрчлийг** хүчингүй болгох, өөрчлөх дүгнэлтийг гаргасан байна. Энэ нь Зөрчлийн тухай хуульд 2023 онд 13 удаа, 2024 онд 16 удаа **нэмэлт, өөрчлөлтийг** оруулснаас шалтгаалсан байх магадлалтай байна.

ЭБАТ-аас 2023-2024 онд оногдуулсан нийт 86,957 шийтгэлийн хуудаснаас 5,019 шийтгэлийн хуудсыг түүвэрлэж үзэхэд³ доорх зөрчил илэрлээ.

► **Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс** Айраг сумын Эрүүл мэндийн төвд улсын бүртгэлийн гэрчилгээнд орсон өөрчлөлтийг хуулийн хугацаанд оруулаагүй зөрчилд 0.2 сая төгрөгийн торгуулийг ногдуулсан нь Зөрчлийн тухай хуульд заасан 0.5 сая төгрөгийн торгуулийн хэмжээтэй нийцэхгүй байна.

Прокурорын байгууллагаас ирүүлсэн судалгаагаар Дорноговь аймагт зөрчил хянан шийдвэрлэх **31 байгууллагын 594 ЭБАТ** байна. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” батлагдсанаар мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар нь өөрсдийн чиг үүрэг бүхий байгууллагуудад харьяалагдан ажиллаж байна. Прокурорын байгууллагаас зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлдэг⁴ тул **эрхгүй албан тушаалтан торгууль тавих боломжгүй** байна.

3. **ТОРГУУЛИЙН ОРЛОГООС ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРДАЛД ХУУЛЬД ЗААСАН ХЭМЖЭЭГЭЭР ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.**

Дорноговь аймгийн хэмжээнд ГХУСАЗСЗ-д **тусгай данс байхгүй** бөгөөд аймаг, сумын ИТХ-ын төсвийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (70709-82201) хөтөлбөрт зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулах **төсвийг баталж** байна.

³ МУЕА-ын 2018 оны А/151 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” заавар
⁴ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих дараах бүрэн эрхийг хэрэжүүлнэ: 1.1.зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах

Аймгийн ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд **320.0 сая**, 2024 онд **432.3 сая** төгрөгийг баталсан байна. Харин хүн ам ихтэй, зөрчлийн тоо өндөр Сайншанд, Замын-Үүд, Хатанбулаг сумдад сүүлийн 2 жилд дунджаар **23.6 сая** төгрөг, бусад сумдад **3.3 сая** төгрөгийг зарцуулахаар сумдын ИТХ-аас баталсан байна.

Аймгийн болон сумын ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг батлахдаа хууль, журамд заасны дагуу өмнөх жилийн торгуулийн төвлөрүүлсэн орлогыг **ХАМААРЧ ҮЗЭЛГҮЙГЭЭР ТОГТМОЛ ДҮНГЭЭР** зардлын төсвийг баталж байна. Жишээлбэл, Айраг сумын 2022 оны цагдаагийн торгуулийн орлогын гүйцэтгэл 68.8 сая төгрөг бөгөөд үүний 40 хувь буюу **27.5 сая** төгрөгийг 2023 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдах зохицуулалттай. Гэвч сумын ИТХ-аар **3.6 сая** төгрөгийг баталсан байгаа нь торгуулийн орлого шаардлагатай зардалд **ЗАРЦУУЛАГДАХГҮЙ**, бусад арга хэмжээний зардлын эх үүсвэрт хуваарилагдах эрсдэлийг үүсгэх юм.

Мөн Авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн орлого авто замын санд хуваарилагдахаар зохицуулалттай. Гэвч Цагдаагийн газраас 2023 онд 261 зөрчилд 30.3 сая төгрөгийн, 2024 онд 234 зөрчилд 26.7 сая төгрөгийн торгуулийг ногдуулсан боловч энэ нь замын сангийн эх үүсвэрт **ХУВААРИЛАГДААГҮЙ** байна.

4. **ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРДЛААС ҮР ДҮНГ НЬ ХЭМЖИХ БОЛОМЖГҮЙ АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨЖ, САНХҮҮЖҮҮЛЖ БАЙНА.**

Аймгийн хэмжээнд 2023 онд 402.6 сая төгрөг, 2024 онд 564.7 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бөгөөд нийт төсвийн **77.7 хувийг** аймгийн ИТХ-аас захиран зарцуулж байна.

(сая төгрөгөөр)

№	Сумын нэр	2023 он		2024 он	
		Төвлөлтөгөө	Гүйцэтгэл	Төвлөлтөгөө	Гүйцэтгэл
1	Аймаг	320.00	314.54	432.30	432.23
2	Айраг	3.65	3.63	12.90	12.88
3	Алтанширээ	2.00	2.00	2.00	2.00
4	Даланжаргалан	5.00	4.99	7.50	7.47
5	Дэлгэрэх	1.55	1.55	2.00	2.00
6	Замын-Үүд	36.04	24.69	35.00	32.16
7	Иххэт	2.00	2.00	2.00	2.00
8	Мандах	2.00	1.92	2.00	1.24
9	Өргөн	4.70	2.48	3.00	2.98
10	Сайншанд	8.00	6.97	18.00	17.77
11	Сайхандулаан	2.00	1.53	2.00	2.00
12	Улаанбадрах	2.00	2.00	7.00	7.00
13	Хатанбулаг	9.68	9.67	35.00	34.91
14	Хөвсгөл	2.00	0.93	2.00	1.66
15	Эрдэнэ	2.00	1.83	2.00	2.00
НИЙТ ДҮН		402.61	380.72	564.70	560.30

Нийт зардлын гүйцэтгэлийн дунджаар 40.9 хувийг **олон нийтийн цагдаагийн урамшуулалд**, 22.0 хувийг **бусад ажилд**, 13.0 хувийг **ЗОРИУЛАЛТ БУСААР**, үлдсэн хувийг сургалт, сурталчилгаа, нийтийн арга хэмжээ зохион байгуулах ажилд зарцуулсан байна.

Зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад 2023, 2024 оны нийт төсвийн 12.5 хувийг **ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН** бөгөөд зөрчлөөс дурдвал:

Аймгийн ГХУСХЗЗ:

- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хүмүүжиж байгаа хүмүүжигчдэд гарын бэлэг
- Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийн хүндэтгэлийн зардал, мөнгөн аяга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байрны болон хоол үйлдвэрлэлийн өрөө, тасалгааны засвар
- Аймгийн ИТХ-ын ажлын албанд компьютер, дэлгэц худалдан авах зардал гэх мэтчилэн

Сумдын ГХУСХЗЗ:

- Төлөөлөгчдийн өдөрлөгийн арга хэмжээний зардал
- “Их говийн нууц” хадны зургийн үзэсгэлэнд оролцох хадны зураг хэвлүүлэх зардал
- Зөвлөлийн хуралдааны хоол, ундны зардал

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг **хууль, журамд заасан хэмжээгээр зориулалтын дагуу зарцуулахгүй байх нь** гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдэж, улмаар нийгмийн аюулгүй байдал, иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагуудын нэгдсэн системийн хангалтгүй байдлаас гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэх үйл явц удаашрах зэрэг **сөрөг үр дагаврыг** бий болгох юм.

Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах зардалд 2023, 2024 онд нийт 65.9 сая төгрөгийг зарцуулсан боловч **ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛООГҮЙ** байна. Өөрөөр хэлбэл, дийлэнх сумын ГХУСАЗЗ-өөс **шатар, үндэсний бөх, бүжгийн тэмцээн, АХА, олимпиад** зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү арга хэмжээ нь **ХЭРХЭН** гэмт хэргээс урьдчилан сэргийлэгдэж байгааг **ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖҮЙ** юм.

5. **ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭД ЭБАТ БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ТОГТМОЛ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОЛОВЧ ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТ СУЛ БАЙНА.**

Монгол Улсын хэмжээнд торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн **НЭГДСЭН САН БАЙХГҮЙ** бөгөөд байгууллагууд салбарынхаа цахим системийг ашиглаж байна.

Оногдуулсан торгуулийг torguuli.police.gov.mn, e-mongolia, smartcar.mn, гэрэгэ болон арилжааны банкны аппликейшнээр дамжуулан төлөх боломжийг бүрдүүлсэн. Торгуулийн орлогын төлбөрийн системээр дамжуулан төлөлт **35.2 хувьтай байсан бол 2024 онд 65.5 хувь болж өссөн** нь орлогын бүрдүүлэлт эерэг нөлөөг үзүүлж байна.

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ САНАЛ БОЛГОСОН АСУУДЛУУД:

1. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн **11.1.5 дахь заалт** нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн **23.7.2, 23.9.2 дахь заалтуудтай НИЙЦЭХГҮЙ** байгааг нэгдсэн тайланд тусгаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах
2. Гаалийн байгууллага, Хилийн цэргийн байгууллага, ХХААГ, Мал эмнэлгийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас оногдуулсан **торгуулийн орлогыг** Төсвийн тухай **хуульд заасны дагуу** орон нутгийн төсвийн эх үүсвэрт төвлөрүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд **уламжлах**

3. Эрх бүхий албан тушаалтнуудын **бүртгэлийн нэгдсэн сантай** болгох чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах
4. Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах **журмыг шинэчлэн батлах** шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ БОЛГОСОН АСУУДЛУУД:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА БӨГӨӨД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Н.АЛДАРБАЯР ТАНАА:

1. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн **ажлын төлөвлөгөөг** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т *“гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгцээ, шаардлага, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашдын төлөв байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн байна”* гэж заасны дагуу төлөвлөх
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт заасан **зориулалтын дагуу зарцуулах**
3. Авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу **замын сангийн эх үүсвэрт төлөвлөж, зарцуулах**
4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т заасны дагуу оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрсөн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувийг хөрөнгийг **дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд төлөвлөж, зарцуулах**

СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА БӨГӨӨД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ:

1. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн **ажлын төлөвлөгөөг** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т *“гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгцээ, шаардлага, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашдын төлөв байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн байна”* гэж заасны дагуу төлөвлөх
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт заасан **зориулалтын дагуу зарцуулах**

АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХ-ЭРДЭНЭ ТАНАА:

- Цаашид Зөрчлийн тухай хуульд заасан мөнгөн дүнгээр торгох шийтгэлийг оногдуулж **ажиллах**, удирдах албан тушаалтнаас дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах

АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Н.БАЯР ТАНАА:

- Байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.БАТЗОРИГ ТАНАА:

- Төвлөрүүлээгүй торгуулийн орлогыг барагдуулах **арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж**, хэрэгжилтийг ханган ажиллах

“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Шалгагдагч байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Зөрчигдөж байгаа хууль, тогтоомж, бодлогын баримт бичгийн заалт
1	Аймаг болон сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд үр дүнг тодорхойлох боломжгүй ажил төлөвлөн, санхүүжүүлж байна.	-	Зөвлөмж өгөх	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг
2	Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулалх салбар зөвлөлөөс 2023-2024 онд нийт 86.6 сая төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. Үүнд: 1. Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хүмүүжиж байгаа хүмүүжигчдэд гарын бэлэг 2. Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийн хүндэтгэлийн зардал, мөнгөн аяга 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байрны болон хоол үйлдвэрлэлийн өрөө, тасалгааны засвар 4. Аймгийн ИТХ-ын ажлын албанд компьютер, дэлгэц худалдан авах зардал 5. Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба, сумдын Засаг дарга нарт сургалт зохион байгуулах гэх мэтчилэн	86.68	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
3	Алтанширээ сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Алтанширээ сумын ГХУСАЗСЗ-өөс гэр бүлийн өдөрлөг, Алтан хонх зэрэг үр дүнг нь тодорхойлох боломжгүй арга хэмжээнд 1.749.500 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	1.75	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
4	Даланжаргалан сумын ИТХ-ын дарга бөгөөд	Даланжаргалан сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онд үр дүнг нь тодорхойлох боломжгүй шатар, бөхийн тэмцээнд 900.000 төгрөгийг, хантааз худалдан авахад 400.000 төгрөгийг, хамтарсан багийн үйл ажиллагаанд 300.000 төгрөгийг нийт	1.60	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46

	ГХУСАЗСЗ-ийн дарга	1.600.000 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.			дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
5	Дэлгэрэх сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Дэлгэрэх сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онд Иргэдээ сонсоё, Төлөөлөгчдийн өдөрлөг арга хэмжээ зохион байгуулах, Үндсэн хууль батлагдсан өдөртэй холбогдуулан бөхийн барилдаан, Жаргалтай гэр бүл зэрэг үр дүнг нь тодорхойлох боломжгүй нийт 1.120.000 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	1.12	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
6	Замын-Үүд сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Замын-Үүд сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад 2.406.700 төгрөгийг зөвлөлийн хуралдааны хоолны зардалд, 1.000.000 төгрөгийг цагдаагийн албан хаагчдын нөхөн сэргээх эмчилгээний зардалд, 2.000.000 төгрөгийг Шүүгчийн зөвлөгөөний зардалд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	5.41	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
7	Иххэт сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Иххэт сумын ГХУСАЗСЗ-өөс 2023 онд шатахуун, бичиг хэргийн материал, зурагт худалдан авахад нийт 851.100 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	0.85	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
8	Мандах сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Мандах сумын ГХУСАЗСЗ-өөс 2023 онд сар бүр 103.600 төгрөгийг шатахууны зардалд нийт 1.036.000 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	1.04	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
9	Сайншанд сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Сайншанд сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад нийт 2.339.721 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна. Үүнд: 1. Сайншанд сумын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албан хаагчид болон сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд ИТХ-ын хяналтын чиг үүрэг, Засаг даргатай харилцах харилцаа сэдэвт сургалт, тэмцээнд зохион байгуулах 2. ИТХ-н ажлын албан хаагчид, тэдний гэр бүлд "Гэр бүлийн	2.34	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг

		үнэ цэнэ" уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах 3. Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулиудын эмч, эрүүл мэндийн хичээлийн сургагч багш нарт эрүүл мэндийн боловсрол олгож чадавхжуулах зэрэг үр дүнг нь тодорхойлох боломжгүй арга хэмжээг санхүүжүүлсэн байна.			
10	Сайхандулаан сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Сайхандулаан сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад зөвлөлийн хуралдааны хоолны зардал, автомашины засварт 1.675.950 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	1.68	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
11	Хатанбулаг сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Хатанбулаг сумын ГХУСАЗСЗ-өөс 2023 онд "Их говийн нууц" хадны зургийн үзэсгэлэнд оролцох хадны зураг хэвлүүлэх ажилд 1.052.100 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	1.05	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
12	Хөвсгөл сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга	Хөвсгөл сумын ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онуудад торгууль төлөхөд 300.000 төгрөгийг, Нэг ангийнхан сургамжит хүүхдийн драмын жүжгийн тоглолтод 326.000 төгрөгийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, журамд заагдаагүй зориулалтаар зарцуулсан байна.	0.63	Зөвлөмж өгөх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг
13	Аймгийн ИТХ-ын дарга	Авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу замын сангийн эх үүсвэрт төлөвлөж зарцуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг
14	Аймгийн ИТХ-ын дарга	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т заасны дагуу оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрсөн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувийг хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд төлөвлөж зарцуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг
15	Улсын бүртгэлийн хэлтсийн даргын	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Айраг сумын Эрүүл мэндийн төвд улсын бүртгэлийн гэрчилгээнд орсон өөрчлөлтийг хуулийн хугацаанд оруулаагүй зөрчилд 0.2 сая	0.25	Зөвлөмж өгөх	Зөрчлийн тухай хууль

	үүргийг түр орлон гүйцэтгэгч	төгрөгийн торгуулийг ногдуулсан нь Зөрчлийн тухай хуульд заасан 0.5 сая төгрөгийн торгуулийн хэмжээтэй нийцэхгүй байна.			
16	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга	Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс 2023 онд торгууль ногдуулаагүй бөгөөд 2024 онд 8 зөрчилд 2.6 сая төгрөгийн ноогдуулсан бөгөөд хөнгөлөлтөд хамрагдаж, 1.3 сая төгрөгийн торгуулийг байгууллагынхаа үндсэн үйл ажиллагааны дансанд хүлээн авч, тайлагнасан.	1.30	Зөвлөмж өгөх	Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь заалт
17	Цагдаагийн газрын дарга	Цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
НИЙТ МӨНГӨН ДҮН			105.69		

-oOo-